

Эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, сургалтын орчны бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч, Доржпалам Баттогтох

2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Дээд боловсролын тухай хуульд заасан журам, дүрэм, стандартыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулсан байна.							
1	Дээд боловсролын тухай хуульд заасан журам, дүрэм, стандартыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг хангахад мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан таниулсан байна.	сайдын тушаал, судалгаа	2008 оны стандарт	Оюутны дотуур байрны ерөнхий стандартын төсөл боловсруулагдсан байна.	Боловсролын сайдын "Ажлын хэсг батлах тухай" 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/149 дүгээр тушаалаар Дээд боловсролын сургалтын байгууллагын “Оюутны дотуур байрны үйлчилгээ, ерөнхий шаардлага”-ын стандартыг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсэг их сургуулиудад " Мэдээлэл ирүүлэх тухай" 4-845 тоот албан бичиг хүргэж, дотуур байрны тухай судалгааг гаргаж, нэгтгэсэн. Одоогийн байдлаар төрийн болон хувийн өмчийн дээд боловсролын байгууллагад	10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 96% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					нийт 69 дотуур байр суралцагчдад үйлчилгээ үзүүлж байна. Эдгээрийн 80 гаруй хувь нь 1999 оноос өмнө ашиглалтад орсон байгууламж байгаа бөгөөд одоогоор мөрдөгдөж байгаа Стандартчилал, хэмжилзүйн үндэсний зөвлөлийн 2008 оны 34 дүгээр тогтоол батлагдсан MNS 5869:2008 стандартын шаардлагыг хангахад учир дутагдалтай байна. Дотуур байрнуудын дийлэнх нь стандартын шаардлага хангаж чадахгүй байгаа ч их, дээд сургуулиуд жил бүр урсгал болон бүрэн засвар хийж байна. Ажлын хэсэгт Эрүүл мэндийн яам, стандарт хэмжил зүйн газар, их, дээд сургуулийн хөрөнгийн менежментийн төв, оюутны холбоо зэргээс албан ёсоор төлөөллүүдийг оруулахаас гадна их сургуулиудын оюутны хөгжил хариуцсан албаны ажилтан, дотуур байрны багш, албан хаагчдыг оролцоог ханган ажиллуулсан. Оюутны дотуур байрны мөрдөгдөж байгаа стандарт, шинээр батлагдсан бусад стандартууд, 2019 оны Оюутны дотуур байрны стандарт нэхцөл байдалд хийсэн эрсдэлийн үнэлгээний тайлан, эрүүл		
--	--	--	--	--	---	--	--

					ахуйн хяналтын хуудас, сургуулиудаас ирүүлсэн санал, судалгаа зэргийг үндэслэн стандартын төслийн саналыг боловсруулсан. Боловсролын сайдын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 1/2452 тоот албан бичгээр “Оюутны дотуур байрны үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS 5869:2008” стандартыг шинэчлэн батлуулахаар стандартын төслийг боловсруулан Стандарт хэмжил зүйн газарт хүргүүлээд байна. . Хавсралт: 5 файл		
1.2. Дээд боловсролын сургалтын байгууллагын хөгжил, үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангах							
2	Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлд чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах зохицуулалтыг гүйцэтгэнэ	Сайдын тушаал	БШУ-ны сайдын 2024 оны 188 дугаар тушаалыг батлуулсан.	Төрийн өмчийн зарим их сургуулийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулна	Дээд боловсролын тухай хууль болон “Дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн нийтлэг дүрэм”-ийн хүрээнд удирдах зөвлөлийн чиг үүргийг хэрэгжүүлэхийг Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөлөлийн нэрсийг Авилгатай тэмцэх газарт 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 1/1141 тоот албан бичгээр хүргүүлсэн. Авилгалтай тэмцэх газраас " Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай"	9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 98% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					2024 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 01/16294 дүгээр албан бичиг ирсэн. Боловсролын сайдын "Монгол Улсын их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/163, "Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/172, " Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/168, "Монгол Улсын боловсролын их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А169, Монгол-Германы технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/170, "Хөдөө аж ахуйн их сургуулийн Удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг шинэчлэн батлах тухай" А/159 дүгээр тушаалууд батлагдсан. Их сургуулиудын Удирдах зөвлөлийн төрийн төлөөллүүдтэй Боловсролын		
--	--	--	--	--	---	--	--

					сайд П.Наранбаяр уулзаж, цаашид ажиллах ажлын төлөвлөгөөний чиглэл, өнөөгийн байдлыг талаар хэлэлцсэн. Их сургуулиудын Удирдах зөвлөлийн төрийн төлөөллийг баталсан тушаалуудыг 2024 оны 10 дугаар сарын 31-ний 4/1884, 4/1885, 4/1886, 4/1887, 4/1888 тоот албан бичгүүдээр хүргүүлсэн. Хавсралт: 7 файл		
3	Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулах журмын төслийг боловсруулна.	Сайдын тушаал	БШУ-ны сайдын 2024 оны 188 дугаар тушаалыг батлуулсан.	Журам сайдын тушаалаар батлагдсан байна.	Боловсролын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/93 дугаар тушаалаар "Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулах журам"-ыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр хуралдаж, журмын төслийг боловсруулах гол зарчим, тусгах асуудлуудыг хэлэлцэн, чиг үүргийн дагуу саналаа боловсруулахаар хэлэлцсэн. Журмын төслийг боловсролын яамны вэб сайтад 2024 оны 10 сарын 15-ны өдрөөс эхлэн сарын	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 97% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хугацаанд тавьсан. Монгол улсад ашиглагдаж байгаа эрдэм шинжилгээний 300 орчим лаборатори байна гэсэн судалгаа байна. Эдгээрээс төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн лабораториуд суурь судалгааны чиглэлийн туршилт судалгаа гол төлөв хийдэг бол төрийн өмчийн их дээд сургуулийн лабораториуд сургалт, судалгаа хосолсон болон сорилтын лабораториуд байна. Ажлын хэсэг журам боловсруулах явцад Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын 4.2.4.2.-д “болон”, “эсхүл”, “буюу” гэсэн холбоос үг нь нэг бол, үгүй бол, аль нэг нь гэсэн утгаар өгүүлбэрийн гишүүдийг зэрэгцүүлэн холбоно” гэж заасанг болон Нөгөөтэйгээр инновацийн тухай хуульд "технологийн туршилт, зүгшрүүлэлт" гэж боловсруулсан технологи, бүтээгдэхүүний загварыг үйлдвэрлэлийн нөхцөлд турших, боловсронгуй болгох, технологийн баримтжуулалт хийх үйл ажиллагаа гэж тусгасанг хэлэлцэн санал гаргаж,		
--	--	--	--	--	--	--	--

					хуулийн зөвлөгөө авсаны дагуу “Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори байгуулж ажиллуулах журам” гэсэн нэрээр боловсруулсан.Энэхүү журам батлагдсанаар судалгаа, шинжилгээ, сорилт, баталгаажуулалтын үр дүнг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх түвшинд хүргэх, үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэлийг бий болгох, тоног төхөөрөмж, хүний нөөцийн ашиглалтыг нэмэгдүүлэх, лабораториудын хоорондын уялдаа холбоог сайжруулах боломжийг бүрдүүлнэ гэж үзэж байна. Хавсралт: 7 файл		
4	Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журмын батлуулна.	Сайдын тушаал	Журмын төсөл	Журам батлагдсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Журам батлах тухай" А/332 дугаар тушаалын хавсралтаар "Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журам" батлагдсан. Журмын төслийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" А/146 дугаар тушаалаар батлагдсан Дээд	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 95% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					боловсролын тухай хууль болон Боловсролын ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсруулах, удирдлага зохицуулалтаар хангахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгээр хэлэлцүүлэн эцэслэн боловсруулсан. Дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллагын багш, судлаач, суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил, бүтээлийн хуулбарлалтын хувь хэмжээг тогтоох, судалгааны ажлын нэгдсэн мэдээллийн санг бий болгох, түүнийг ашиглахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах зорилгоор энэхүү журмыг боловсруулсан. Журмыг дээд боловсролын байгууллага, эрдэм шинжилгээний судлаач, багш суралцагч, Шинжлэх ухаан, технологийн сан, цахим дэд бүтэц хариуцагч даган мөрдөнө. Журмын дагуу бакалаврын дипломын ажил, магистрын төгсөлтийн ажил, докторын диссартац, эрдэм шинжилгээний өгүүлэл, төслийн тайлан, сурах бичиг, гарын авлага болон нэг сэдэвт бүтээлийн хуулбарлалтыг шалгах боломжтой юм. Уг журмыг		
--	--	--	--	--	---	--	--

					2025 оны 01 сарын 1-ний өдрөөс эхлэн өмчийн хэлбэр үл харгалзан дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага баримтлан ажиллахаар зааж өгсөн. Хавсралт: 2 файл		
5	Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журмыг батлуулна.	Сайдын тушаал	Журмын төсөл	Журмыг батлуулсан байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны "Нийтлэг журам батлах тухай" А/331 дүгээр тушаалын хавсралтаар "Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журам" батлагдсан. Журмын төслийг Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн даргын "Ажлын хэсэг байгуулах тухай" А/146 дугаар тушаалаар батлагдсан. Дээд боловсролын тухай хууль болон Боловсролын ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээний актын төслийг боловсруулах, удирдлага зохицуулалтаар хангахад дэмжлэг үзүүлэх ажлын хэсгээр хэлэлцүүлэн эцэслэн боловсруулсан. Энэхүү журмын гол зорилго нь сургуулийн хөгжил,	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 96% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					судалгаа, эрдэм шинжилгээ, инновацын зорилтот арга хэмжээг санхүүжүүлэхэд оршино. Эндаументын сангийн хөрөнгө нь иргэн, аж ахуй нэг, байгууллагаас ашиг олох зорилгогүй шилжүүлсэн мөнгөн хөрөнгө, үнэт цаас мөн хүүгийн болон ноогдол ашгийн орлогоос гадна иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас шилжүүлсэн үл хөдлөх хөрөнгө, лабораторийн тоног төхөөрөмж, ббагаж хэрэгсэл зэргээс бүрдэнэ. Батлагдсан нийтлэг журамд нийцүүлэн сургуулийн Удирдах зөвлөлөөс эндаументын сангийн журмыг баталж, зарцуулалтад хяналт тавин ажиллахаар зохицуулж өгсөн. Хавсралт: 2 файл		
3.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах							
6	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнах	Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн тоо	2023 оны биелэлтийн хувь	Холбогдох заалтын хэрэгжилт хангагдсан байна.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн холбогдох заалтуудын биелэлтийг гаргаж ажилласан. Төрийн өмчийн зарим их сургуулийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-1, Дугаар 2024_207, 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 51 дүгээр тэмдэглэл, 2022 оны 7 дугаар сарын 27-ны өдөр 38	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 97% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа

					дугаар тэмдэглэл 2022-07-27 Дугаар 2022_38, 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр 3 дугаар тэмдэглэл 2023-01-11 Дугаар 2023_3, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 52 дугаар тэмдэглэл 2023-12-27 Дугаар 2023_52, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны 19 дүгээр тэмдэглэл 2024-05-15 Дугаар 2024_19.1 зэрэг шийдвэрийн хэрэгжилтийг хангуулахаар хамтран ажиллаж байна. Хавсралт: 1 файл		гүйцэтгэсэн байдал: 100%
7	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг тайлагнах	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хугацаанд тайлагнасан байна. Хэрэгжилт хангагдсан байна.	Монгол улсын засгийн газрын 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг цаг тухайд гарган тайлагнаж ажилласан. Төлөвлөгөөнд эрдэм шинжилгээ, судалгааны талаар судалгаа, шинжилгээний ажлын санхүүжилтийг нэмэгдүүлж, орлогын олон талт (эндоумент, венч сан) эх үүсвэрийг бий болгох, судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл,	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 97% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					бүтээл, патент бүрийг урамшуулах тогтолцоог бий болгож, шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, төрийн өмчийн их, дээд сургуулиудын судалгааны болон бусад зардалд төрөөс зарим дэмжлэг үзүүлэх зэрэг чухал арга хэмжээнүүд тусгагдаж, 2024 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлтээр дүгнэхэд хэрэгжилт хагалттай сайн байна. Хавсралт: 1 файл		
8	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнах.	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна	Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт салбарын чиглэлээр тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг заасан хугацаанд тайлагнаж ажилласан. Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлд Судалгааны үр дүнд бий болсон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрдэм шинжилгээний өгүүлэл, бүтээл, патентыг эдийн засгийн эргэлтэд оруулах, Бүс нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн КООСЭН сургалтын хөтөлбөрийг аймаг бүрд мэргэжлийн болон техникийн	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 97% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					боловсролын сургалтад нэвтрүүлэх зорилт, арга хэмжээ тусгагдсан бөгөөд хэрэгжилт, үр дүн сайн хангагдсан. Шинэ суурьшлын бүс, дагуул хот, эдийн засгийн чөлөөт бүсийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлж, Улаанбаатар хотоос орон нутагт шилжин суурьшсан иргэд, аж ахуйн нэгжүүдийг цогц бодлогоор дэмжих замаар төвлөрлийг сааруулах хүрээнд Зарим их, дээд сургуулийг дагуул хотууд болон орон нутагт шилжүүлсэн. Хавсралт: 3 файл		
9	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг тайлагнах	Зорилтын тоо, шалгуур, хэрэгжилтийн хувь	2023 оны тайлан	Хэрэгжилт хангагдсан байна. Хугацаандаа тайлагнасан байна.	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг цаг тухайд нь тайлагнаж ажилласан. Судалгаа хөгжүүлэл-тийн ажлын үр дүнд бий болсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлсэн төсөл хэрэгжүүлэх, гарааны компани байгуулах, Үр дүнд суурилсан өрсөлдөөнт болон тогтмол санхүүжилтээр хийгдсэн шинжлэх ухаан, технологийн /суурь, хэрэглээ-ний, технологи/ судалгаа хөгжүүлэлтийн ажлыг	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 98% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					дэмжих ажлууд хийгдсэн. “Шинжлэх ухаан технологийн сэргэлт: Их сургуулиудын оролцоо” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлаас гарсан зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажилласан. Хавсралт: 1 файл		
3.1. . Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах							
10	Яамны болон салбарын мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллана.	Мэдээллийн тоо, хэрэгжилтийн хувь	2023 оны байршсан мэдээлэл	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан бүх мэдээлэл байршсан байна.	Төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох, батлагдах дүрэм, журамд олон нийтийн саналыг зорилгоор Боловсролын яамны вэб сайтад Дээд боловсролын тухай хуулийн 22.8.-д “Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулах журам”-ын төслийг 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 15-ны өдрийг дуустал байршуулж саналыг хүлээн авсан.	8-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 97% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
11	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага,	Хууль тогтоомжийн хүрээнд судлан шийдвэрлэж,	-	Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан байна.	Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар,	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн

	албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд нь мэдүүлж, төрийн жинхэнэ албан хаагчийн ёс зүйн гэрээг чандлан мөрдөж, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллана.	хариу төлөвлөн хүргүүлсэн байдал /гүйцэтгэлийн тоо, чанар, хүртээмж			Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын Ахлах мэргэжилтнээс Боловсролын яамны Дээд боловсролын газар Шинжээчээр ажиллах болсон тул чиг үүрэгт хамаарах ажлын материалуудыг архивлан 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдөр хүлээлгэн өгсөн. Үүнд: Судалгааны үндсэн чиглэлээр- 2 боть, Суурь судалгааны төсөлтэй холбоотой-9 боть, Монгол судлалыг дэмжих үйл ажиллагаатай холбоотой -2 боть нийт 13 боть баримт бичиг байна. Мөн ажлын чиг үүрэг өөрчлөгдсөн тул ХАСХОМ-ийн мэдүүлгийг хугацаанд нь мэдүүлж, баталгааны маягыг яамны хүний нөөцөд бүртгүүлсэн. Дээрх хугацаанд иргэдээс 24 өргөдөл, гомдол авч шийдвэрлэж, иргэд байгууллагаас 75 албан бичиг ирүүлсэн бөгөөд үүнээс хариутай 52, хариугүй 23, боловсруулан явуулсан 60 албан бичиг байна. 2024 оны 8 сарын 14-өөс хойшхи хугацаанд Боловсролын сайдын 21 тушаалын төслийг боловсруулан батлуулсан байна.	12-р сар	даргын үнэлгээ: 98% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	--	--	--	--	----------	--

					Хавсралт: 4 файл		
--	--	--	--	--	------------------	--	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Монгол бичгийн сургалтад хамрагдана.	Монгол бичгийг талаарх мэдлэгээ дээшлүүлсэн байна.	Анхан шатны мэдлэгтэй	Монгол бичгийн талаарх мэдлэг дээшилсэн байна.	Монгол бичгийн талаарх мэдлэг, чадвараа дээшлүүлсэн. Төрийн жинхэнэ албан хаагчийн тусгай шалгалтад бэлтгэх зорилгоор Монгол бичгийн дунд шатны сургалтад хамрагдаж, Төрийн албан хаагчдад зориулсан "Монгол бичгийн гарын авлага"-ыг бие даан судалсан. Хавсралт: 1 файл	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
2	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших,	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших,	-	Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжийг бие даан судалсан	1. Боловсролын багц хуулийн шинэчлэлтэй холбоотой 2024 оны төлөвлөгөөнд орсон бүх дүрэм журам болон Дээд боловсролын салбарт хийгдсэн онцлог ажлуудын мэдээллийг эмхэтгэсэн "Дээд боловсролын	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

	тасралтгүй хөгжүүлнэ.	тасралтгүй хөгжүүлнэ.		байна.	бодлогын баримт бичгийн эмхэтгэл 2024" ном хэвлэгдэн гарсанг салбарынханд түгээн танилцуулж сурталчилсан. 2. Төрийн жинхэнэ албаны тусгай шалгалтад бэлтгэх зорилгоор Хууль, эрх зүй, бодлогын баримт бичгийн талаарх мэдлэг дээшлүүлэх сургалтад хамрагдсан. Хавсралт: 1 файл		
--	--------------------------	--------------------------	--	--------	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрдэм шинжилгээ, сургалт, судалгаа, сургалтын орчны бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан шинжээч, Доржпалам Баттогтох
/...../ Огноо: